



МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК ХК

2019 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

« Ногдол ашиг хувиарлах тухай »

Монгол Улсын компанийн тухай 46 дугаар зүйлийн 46.5, дахь заалт, 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ийн 2018 оны тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 160,666,160.11 төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 12,356,449.31 эргэлтийн хөрөнгийг 148,309,710.80 төгрөгөөр, нийт үйл ажиллагааны орлогыг 44,273,649.15 төгрөгөөр, ашиг 2,360,043.83 төгрөгөөр тус тус тооцож тайлан тэнцлийн дүнг баталсугай.
2. Компани нь 2018 онд 2,360,043.83 төгрөгийн ашигтай ажиллаж байгаатай холбогдуулан 2018 оны ногдол ашгийг хувиарлахгүй байхаар тогтоосугай.
3. Ногдол ашиг хувиарлахгүй талаар хувьцаа эзэмшигч нарт мэдэгдэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /П.Эрдэнэчулуун/-д даалгасугай.
4. 2019 онд бизнесийн үйл ажиллагааг эрчимжүүлж, илүү өндөр ашигтай ажиллах талаар идэвхи санаачлага гарган ажиллахыг Гүйцэтгэх захирал /Л.Гүндэгмаа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



З.НОМУНДАРЬ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Г “Монгол секюритиес” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Энх-тайваны өргөн чөлөө, “22-р бааз” ХК-ийн байр 201 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
2. Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
3. Санхүүгийн тайланд хийсэн аудитийн дүгнэлт.
4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
5. Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

4. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

7. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2019 оны 04 сарын 23-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.

8. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Б.Баярсайхан дарга
- Ш.Наранхүү гишүүн

9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисс даалгасугай. .

10. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Монгол секюритиес” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Б.Баярсайхан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/З.НОМУНДАРЬ/

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Монгол секюритиес ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /Л.Гүндэгмаа/-д даалгасугай.

: Төлөөлөн Удирдах Зөвлөл энэ удаа хэлэлцэн шийдвэрлэхээр төлөвлөсөн асуудлаа бүгдийг хэлэлцэн шийдвэрлэсэн учраас хурлын ажиллагаа дуусгавар болж байна. Хурлыг 15 цаг 10 минутанд хаалаа.

ТУЗ-ийн ДАРГА

ГИШҮҮД



ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН

З.НОМУНДАРЬ

Т.ЭРДЭНЭБААТАР
Л.ГҮНДЭГМАА
Т.ЗОРИГТБААТАР
Д.ЭРДЭНЭЧУЛУУН
Б.БАЯРСАЙХАН
А.БААТАРЖАВ
Ч.ЭНХТУЯА

З.О

З.ОЮУНБИЛЭГ



МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК ХК

2017 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 01.

Улаанбаатар хот


ТУЗ-ИЙН ТОГТООЛ

“МОНГОЛ СЕКЮРИТИЕС ҮЦК” ХК-ийн ТУЗ-өөс “Компанийн Тухай Хууль”-ийн 6-р бүлгийн 46.5-ийг үндэс болгон ТОГТООХ НЬ:

2018 оны үйл ажиллагааны зардал, зах зээлийн өнөөгийн байдал зэргээс үүдэн 2019 онд ноогдол ашиг тараах боломжгүй гэсэн шийдвэр гаргаж байна.

Хуудас:

ТУЗ-ИЙН ДАРГА



З.НОМУНДАРЬ

Улаанбаатар-13, Шуудангийн хайрцаг-1084
Улаанбаатар, Баянзүрх дүүрэг
8-р хороо, “22-р Бааз” ХК-ний байр
Утас: 976-11-70120708
Факс: 976-11-70110708

Ulaanbaatar-13, P.Box-1084
Ulaanbaatar, Bayanzurkh District,
8th Khoroo, 22nd Baaz Building
Phone: 976-11-70120708
Fax: 976-11-70110708